



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 05 дугаар сарын 09 өдөр

Дугаар 14

Хэрлэн сум

XIV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 14 дүгээр хуралдаан 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 14:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд цомхотгосон хэлбэрээр 88,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Улсын хэмжээнд зохион байгуулагдах “Стратегийн команд штабын дадлага, сургууль”-ийн талаар мэдээлэл танилцуулах,
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын орлогч,
Урьдчилан сэргийлэх тасгийн дарга, Онцгой комиссын
нарийн бичгийн дарга, хошууч Б.Цогтбаяр-д:

1.1. Улсын хэмжээнд зохион байгуулагдах “Стратегийн команд штабын дадлага, сургууль”-ийн бэлтгэл ажлын хүрээнд Дорнод аймгийн ослын удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүнийг томилгоожуулах Засаг даргын захирамжийн төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

1.2. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг 19, Тосон-Уул 21 дүгээр талбайд Онцгой байдлын газрын гал түймэр унтраах бүлгийг томилж ажиллуулах, шаардагдах зардлыг тооцож танилцуулах,

1.3. Хээрийн түймрийн эрсдэл өндөртэй хавар, намрын хуурайшилтын улиралд аймгийн хэмжээнд “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т шилжүүлэн ажиллуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргаж батлуулах,

Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

1.4. Гурванзагал, Чойбалсан сумын нутаг дэвсгэрийг хамарсан хээрийн түймрийн нөөлөгт өртсөн 3 иргэний ар гэрээс Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэж буй 3 иргэний ар гэрт эмчилгээний зардалд дэмжлэг үзүүлэх зорилгоор Дотоодын хүмүүнлэгийн тусламжийн сангаас 3,0 сая төгрөгийг олгохыг зөвшөөрөв,

/  / М.Бадамсүрэн
/  / х/ч Б.Цогтбаяр

Хоёр.Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга нарт:

2.1.Уул уурхай, газрын тосны томоохон компаниудын төслийн талбай дээр гамшиг ослоос хамгаалах зорилгоор Байгаль хамгаалагчийг ээлжээр цалинжуулж ажиллуулах,

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга,
Онцгой комиссын гишүүн А.Гантулга,
Байгаль хамгаалалтын захиргааны
дарга Б.Эрдэнэбаяр нарт:

2.2.Байгаль орчин, аялал жуулчлалын газар, тусгай хамгаалалттай сав газруудын захиргааны хариуцсан нутаг дэвсгэр алслагдсан газруудад хавар, намрын хуурайшилт, ан гөрөө хийх улирлуудад харуулыг томилж ажиллуулах, цалинжуулах зардлыг тооцож шийдвэрлүүлэх,

Аймгийн Засаг даргын тамгын газрын
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,
Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх,
Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,
Зүүн бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга,
Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах нарт:

2.3.Бүтээгдэхүүн хуваах гэрээт Тамсаг 19, Тосон-Уул 21 дүгээр талбай, Меланж ХХК, Степ голд ХХК, Шинь Шинь ХХК-уудтай хамтран тухайн аж ахуйн нэгждэд хавар, намрын хуурайшилтын улиралд шуурхай бүлгийг томилгоожуулж бэлэн байдлыг хангуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХОШУУЧ

Б.ЦОГТБАЯР

